


**БАТЛАВ.
МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ГИШҮҮН**



Г.ТЭМҮҮЛЭН

**БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2."Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн", Арван зургадугаар зүйлийн 4-т "ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цагин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй". Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин зургадугаар зүйлийн 3-т "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтооно" гэж заасан байна.

Үүний дагуу сум, дүүргийн боловсролын газрын дарга, ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийн сонгон шалгаруулалт, томилогдох чөлөөлөгдөх нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан дээдлэх зарчим, Төрийн албаны тухай хуульд заасан зарчимтай уялдан холбогдох хуулиар зохицуулагдах ёстой.

Ерөнхий боловсролын сургуулийн захирал хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч нь Төрийн албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2.боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, соёл, урлаг, спорт зэрэг төсвөөс санхүүждэг төрийн үйлчилгээний байгууллагын дарга, захирал, эрхлэгч, бусад удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаал хэмээн тусгасан байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн нийтлэг зарчим зохицуулалтыг төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид үйлчлэх агуулгатай.

Энэхүү хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2-т "Мэргэшсэн, тогтвортой байх", 7.1.3-т "улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх" зарчмуудыг төрийн албан хаагчийг томилох, чөлөөлөхдөө баримтлах ёстой.

Гэтэл Боловсролын тухай хуульд 2018 оны 06 дугаарын сарын 21-ний нэмэлт өөрчлөлтөөр тус хуулийн 31 дугаар зүйлийн 31.1.12 "Аймаг, нийслэлийн боловсролын газрын сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийг томилох, тэдгээрийг үр дүнгийн гэрээний хэрэгжилт болон аймаг, нийслэлийн боловсролын газрын саналыг

үндэслэн чөлөөлөх” нэмэлт өөрчлөлт нь Үндсэн хуулийн агуулга, зарчим болон Төрийн албаны тухай хуулийн зохицуулалттай зөрчилдөж байна.

Сум, дүүргийн засаг дарга нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.”Энэ хуулийн 26.2-т зааснаар нэр дэвшүүлсэн бол аймаг, нийслэлийн Засаг даргыг Монгол Улсын Ерөнхий сайд, сум, дүүргийн Засаг даргыг аймаг, нийслэлийн Засаг дарга, баг, хорооны Засаг даргыг сум, дүүргийн Засаг дарга тус тус 4 жилийн хугацаагаар томилох бөгөөд нөхөн томилогдсон Засаг даргад энэ хугацаа хамаарахгүй”, Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.9 “бүх шатны Засаг дарга болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын орлогч” 4 жилийн хугацаатай томилогддог улс төрийн албан тушаалтан юм.

Иймд төрийн үйлчилгээний албан тушаалтныг улс төрийн албан тушаалтан томилох, чөлөөлөх нь хууль зүйн хувьд зарчим, агуулгын зөрчилдөөн бий болгож байна. Мөн ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийг томилох чөлөөлөх бүрэн эрх нь засаг даргад хуулиар олгосноор төрийн албаны хэвийн тасралтгүй явагдахад саад учруулж болзошгүй нөхцөл байдлыг бий болгож байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа -2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 1 дүгээр хавсралтын Зорилт 2.1. I үе шатны 3-т заасан “Суралцагчийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагыг хангасан, бүтээлч, чадварлаг багш, хүний нөөцөөр хангана”, Зорилт 5.4 I үе шатны 1-т “Чадахуйн зарчимд суурилсан, мэргэшсэн төрийн алба төлөвшсөн байна”, 2-т “Сонгуулийн үр дүнгээс үл хамааран төрийн албан хаагч тогтвортой ажиллах нөхцөл бүрдэж, төрийн албаны шатлан дэвшүүлэх тогтолцоо боловсронгуй болсон байна” тусгасан. Үүний дагуу Улсын Их хурлаас үүнтэй уялдуулан 2021-2030 онд энэхүү хөгжлийн бодлогын хүрээд хууль батлан гаргах, шинэчлэн найруулах, нэмэлт өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага бий болж байна.

Мөн төрийн байгууллага нь босоо тогтолцоотой буюу шууд удирдлага дор үйл ажиллагаагаа явуулдаг үүний дагуу бусад төрийн байгууллагатай уялдаа холбоотой ажилладаг. Гэтэл тухайн нэг салбарын шууд удирдлагад хамаарах субъект буюу ерөнхий боловсролын захирал, эрхлэгчийг Засаг дарга томилох, чөлөөлөх эрхийг хууль олгосон нь төрийн албаны томилогооны үйл ажиллагааг саад учруулах, удаашруулах, үе шатыг нэмэгдүүлж байна.

Дээрх үндэслэлүүдийн хүрээнд Боловсролын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулна.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл нь хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийн төрөлд хамаарна.

Боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөлд дараах зохицуулалтыг тусгана.

1/ Аймаг, нийслэлийн боловсролын газрын сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийг томилох, тэдгээрийг үр дүнгийн гэрээний хэрэгжилт болон аймаг, нийслэлийн боловсролын газрын саналыг үндэслэн чөлөөлөх гэх заалтыг хүчингүй болгох

2/ Орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, томилж, чөлөөлдөг байх зохицуулалтыг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Хуулийн төсөлд батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2-т "...хуульд захирагдах..." гэж заасны дагуу төрийн албаны хуульд нийцүүлэх, төрийн албаны тогтвортой байдлыг ханган хууль зүйн шаардлагыг хангана.

Засаг даргын улс төрийн ашиг сонирхлын зөрчилдөөнтэй шийдвэр гаргаж болзошгүй нөхцөл байдлыг арилгах, тухайн сум, дүүргийн боловсролын салбарын үйл ажиллагаанд ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийг томилохгүй, эс үйлдэхүйгээр саад учруулж болзошгүй сөрөг үр дагаврыг арилгана.

Мөн нийгмийн суурь салбар болох боловсрол соёл хүмүүжлийн салбарын үйл ажиллагаа удирдлагыг мэргэшсэн тогтвортой болгох, Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2-т "Мэргэшсэн, тогтвортой байх", 7.1.3-т "улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх зарчмуудыг хэрэгжилтийг хангах, улс төрийн албан тушаалтнаас хараат бус, хөндлөнгийн нөлөөллөөс ангид болгох ач холбогдолтой.

Боловсролын тухай хуулийн 28¹ дүгээр зүйлд Аймаг, нийслэлийн боловсролын боловсролын газрын бүрэн эрхэд сум, дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийг сонгон шалгаруулж томилох, үр дүнгийн гэрээний хэрэгжилтийг дүгнэн чөлөөлөх нь төрийн байгууллагын бодлого шийдвэрийг шууд хэрэгжүүлэхэд ач холбогдолтой юм.

Хуулийн төсөл батлагдсаны дараа эдийн засаг, нийгэм, хууль зүйн сөрөг үр дагавар гарахгүй бөгөөд улсын төвөөс нэмэлт хөрөнгө шаардагдахгүй.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн, бусад хуультай уялдсан байх бөгөөд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинээр хууль боловсруулах, хүчингүй болсонд тооцох шаардлагагүй болно.